



I-XII/2021

Тархаасан: 2022 оны 01 дүгээр сарын 14



## Эхийн эндэгдлийн харьцаа (100 000 амьд төрөлтөд ногдох) 2021 онд 95 болж, өмнөх оноос 65 (3.1 дахин)-аар нэмэгджээ

Улсын хэмжээнд 2021 онд 71.2 мянган эх амаржсан нь өмнөх оноос 4.5 мянга (6.0%)-аар буурсан байна. Амаржсан эхчүүдийн 76.0 хувь нь 6, түүнээс дээш удаа жирэмсний хяналтад хамрагдсан нь өмнөх оноос 2.5 нэгж хувиар өсжээ. Нийт амаржсан эхчүүдийн 206 (0.3%) нь гэртээ төрсөн байна.


ХҮСНЭГТ 1. АМАРЖСАН ЭХ, ТӨРСӨН ХҮҮХЭД, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	<u>2021</u> <u>2020</u>
	Тоо				Хувь
Амаржсан эх	77 058	77 601	75 694	71 166	94.0
6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	58 669	57 343	55 643	54 064	97.2
Гэрийн төрөлт	307	229	236	206	87.3
Амьд төрсөн хүүхэд	77 528	78 223	76 261	71 659	94.0
1 цагийн дотор хөхөө амласан хүүхэд	74 768	75 654	73 610	68 690	93.3
Төрөлхийн гажигтай төрсөн	533	620	617	541	87.7
2500 граммаас доош жинтэй төрсөн	3 421	3 415	3 413	3 009	88.2
Амьгүй төрсөн хүүхэд	438	405	413	397	96.1
Амьгүй төрөлтийн түвшин (1000 нийт төрөлтөд ногдох)	6	5	5	6	-

Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

2021 онд нийт 71.7 мянган хүүхэд төрж, өмнөх оноос 4.6 (6.0%) мянгаар буурчээ. Нийт төрсөн хүүхдийг сараар харахад 7 дугаар сард хамгийн их буюу 6.4 мянган хүүхэд төрсөн бол 12 дугаар сард хамгийн бага буюу 5.3 мянган хүүхэд төрсөн байна.

ЗУРАГ 1. АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД, сараар



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Нийт амьд төрсөн хүүхдийн 68.7 мянга (95.9%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан, 541 (0.8%) нь төрөлхийн гажигтай, 3009 (4.2%) нь 2500 граммаас бага жинтэй байна. Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд 6 ногдож байна.

Улсын хэмжээнд 2021 онд нас баралтын 19.9 мянган тохиолдол бүртгэгдсэн нь 2019 оноос 2.7 (15.8%) мянгаар, 2020 оноос 4.0 (25.2%) мянгаар өсжээ. Нийт нас баралтын 6941 (34.8%) нь эмнэлэгт, 12988 (65.2%) нь гэрийн (бусад газарт) нас баралт байна.

## ХҮСНЭГТ 2. НАС БАРАЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	<u>2021</u> 2020
	Тоо				хувь
Нас баралт	17 331	17 205	15 922	19 929	125.2
Эмнэлэгт нас баралт	4 721	4 905	4 462	6 941	155.6
Гэртээ (бусад газарт)	12 610	12 300	11 460	12 988	113.3
Эхийн эндэгдэл	21	18	23	68	3.0 <sup>1</sup>
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1 310	1 263	1 065	993	93.2
Нялхсын эндэгдэл	1 037	1 041	878	829	94.4
Нярайн эндэгдэл	672	647	596	591	99.2
Эхийн эндэгдлийн харьцаа	27	23	30	95	3.1 <sup>1</sup>

<sup>1</sup> Дахин их


Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

2021 онд 68 эхийн эндсэн нь өмнөх оноос 45 (3 дахин)-аар нэмэгджээ. Эхийн эндэгдлийн харьцаа (100 000 амьд төрөлтөд ногдох) 95 болж, өмнөх оноос 65 (3.1 дахин)-аар нэмэгдсэн байна. Нийт эндсэн эхийн 46 (67.6%) нь коронавируст халдварын хүндрэлийн улмаас нас баржээ.

Улсын хэмжээнд 2021 онд нийт нас баралтын 5.0 хувийг 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 83.5 хувийг нялхсын эндэгдэл, нялхсын эндэгдлийн 71.3 хувийг нярайн эндэгдэл эзэлж байна.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 2021 онд 14, нялхсын эндэгдлийн түвшин 12, нярайн эндэгдлийн түвшин 8 болж, өмнөх оныхтой адил түвшинд байна.

## ЗУРАГ 2. ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙН ТҮВШИН (1000 АМЬД ТӨРӨЛТӨД НОГДОХ), жил бүрийн эцэст



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2021 онд 576.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 542.6 мянга (17.3 дахин)-аар нэмэгдэхэд коронавирусний халдварын 561.2 мянган (97.4%) тохиолдол бүртгэгдсэн нь нөлөөлжээ.

### ХҮСНЭГТ 3. ХАЛДВАРТ ӨВЧИН, ЗАРИМ ӨВЧНИЙ ТӨРЛӨӨР, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	<u>2021</u> 2020
	Тоо				хувь
<b>Халдварт өвчнөөр өвчлөгчид</b>	<b>42 074</b>	<b>45 232</b>	<b>33 376</b>	<b>575 989</b>	<b>17.3<sup>1</sup></b>
Вируст хепатит	475	527	353	131	37.1
Сүрьеэ	3 498	3 624	3 339	2 331	69.8
Салхин цэцэг	8 130	10 652	2 883	293	10.2
Гар, хөл, амны өвчин	2 876	2 147	2 097	137	6.5
Цусан суулга	6 265	5 438	2 630	732	27.8
Тэмбүү	6 163	7 095	6 555	3 617	55.2
Гонококкт халдвар	5 461	5 772	5 131	3 040	59.2
Трихомониаз	4 488	4 980	4 446	2 667	60.0
ХДХВ/ДОХ	18	18	25	16	64.0
Мөөгөнцөр	1 748	1 917	3 392	1 429	42.1
Коронавируст халдвар	-	-	1 215	561 194	461.9 <sup>1</sup>

<sup>1</sup> Дахин их

Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Харин коронавирусний халдвараас бусад төрлийн халдварт өвчин өмнөх оноос 30.2-93.5 хувиар буурсан байна. Тухайлбал, гар, хөл, амны өвчнөөр өвчлөгчид 1960 (93.5%)-аар, салхин цэцгээр өвчлөгчид 2590 (89.8%)-ээр, вируст хепатитаар өвчлөгчид 222 (62.9%)-оор, мөөгөнцрөөр өвчлөгчид 1963 (57.9%)-аар, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөр өвчлөгчид 6817 (42.2%)-гоор тус тус буурчээ.

Улсын хэмжээнд 2021 онд ХДХВ/ДОХ-ын 16 тохиолдол илэрч, нийт тохиолдол 327 болсон байна.

#### Аргачлалын тайлбар:

**Нярайн эндэгдлийн түвшин** (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Нялхсын эндэгдлийн түвшин** (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин** (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Эхийн эндэгдлийн харьцаа** (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Амьд төрөлт:** Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайгаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйн судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

**Амьгүй төрөлт:** Жирэмсний 22 долоо хоног ба түүнээс хойших хугацаанд, 500 граммаас дээш жинтэй төрсөн нярайд амьдын шинж тэмдгийн аль нь ч (зүрхний цохилт, судасны лугшилт, булчингийн хөдөлгөөн) илрэхгүй байгааг хэлнэ.

**Эндсэн эх:** Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

**Амьгүй төрөлтийн түвшин** (1000 нийт төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд нийт төрсөн хүүхдийн тоог амьгүй төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.



**Эх үүсвэр:**

Эрүүл Мэндийн Яамны сарын мэдээ

**Ангилал, код:**

Өвчний олон улсын ангилал /ICD-10/.

**Мэдээлэл авах холбоос:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:**

2023 оны 1 дүгээр сарын 17

Нийгмийн статистикийн газрын  
дарга А.Амарбал  
Утас: (976-51)-264805

Нийгмийн статистикийн газрын  
статистикч Т.Оюунсүрэн  
Утас: (976-51)-263966



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212